

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН  
2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ  
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 10 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан журмын дагуу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2021 онд хэрэгжиж эхэлсэн дуусаагүй барилгуудыг магадлалын дүгнэлтийг үндэслэн 2022 онд дуусгах хөрөнгийг шийдвэрлэх боломжтой эсэх, аудитын дүгнэлтэд төлөвлөлтийн шаардлага хангаагүй гэж тусгагдсан хөрөнгө оруулалтын 62 төсөл, арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтэрэл Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалт хийх газар чөлөөлөлтэд хамрагдсан малчдыг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговортой холбоотой зардал төсөвт тусгагдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих урамшууллыг олгож байгаа зарчмын талаар мөн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход чухал нөлөөтэй малыг эрүүлжүүлэх зардал төсөвт тусгагдсан эсэх, түүнчлэн Улсын Их хурлын гишүүн С.Ганбаатар, Ш.Раднаасэд, Ш.Адьшаа, Д.Батлут, Д.Өнөрболов нар уул уурхайн металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк болон Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн шахмал тулшний үйлдвэр, орон нутагт баригдах дулааны станцуудын хөрөнгийн эх үүсвэрийн талаар мөн 2022 оны төсвийн орлогод уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлогод эрсдэлийг хэрхэн тооцсон, Төсвийн тухай хуулийн өөрчлөлтийн дагуу тооцоологдсон Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтын талаар асуулт асууж, хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй 4 санал гарсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын


чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.6 дахь хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн ёв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.БАТЖАРГАЛ